



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2012 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 93

Улаанбаатар хот

“Мандал генерал даатгал” ХХК-ийн
дүрмийн санд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 21.5, 22.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 3,2 дахь заалт, “Мандал генерал даатгал” ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Мандал генерал даатгал” ХХК-ийн дүрмийн сангийн хэмжээг 1,0 тэрбум төгрөгөөр бууруулж, 5,2 тэрбум төгрөг болгохыг дараахь байдлаар зөвшөөрсүгэй:

№	Хувь нийлүүлэгч	Дүрмийн сангийн хэмжээ /мянган төгрөгөөр/			Дүрмийн санд эзлэх хувь
		Эхний үлдэгдэл	Буурсан өөрчлөлт	Эцсийн үлдэгдэл	
1	/Mongolia Growth Group” Ltd/	6,243,016,0	1,000,000,0	5,243,016,0	100,0 %
	Дүн	6,243,016,0	1,000,000,0	5,243,016,0	100,0 %

2. Дүрмийн сангийн хэмжээг бууруулсан өөрчлөлтийг тусгай зөвшөөрлийн болон улсын бүртгэлийн гэрчилгээнд тэмдэглүүлж, шинэчилсэн дүрмийг улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн холбогдох баримтыг 2012 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Мандал генерал даатгал” ХХК /М.Давааням/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд бичилт хийж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН

